



ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нийтлэг зүйл

Монголын Мянганы сорилтын сан (“Монголын МСС” гэх)-ийн Хүний нөөцийн гарын авлага–Хөдөлмөрийн дотоод журам (“Хүний нөөцийн гарын авлага” гэх)-ын хавсралт болох Ёс зүйн дүрэм (“Дүрэм” гэх)-ийн үндсэн зорилго нь Монголын МСС-ийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээний талаарх цогц ойлголтыг нийт ажилтнуудад өгч, ажил олгогчийн зүгээс баримталж буй бодлого, шаардлагыг тодорхой болгох, улмаар ажилтнууд тэдгээр хэм хэмжээг сахин биелүүлэх нөхцөлийг хангахад оршино. Энэхүү дүрэм нь Монголын МСС-ийн захиргааны суурь зарчим, үндсэн дүрэм болох бөгөөд байгууллагын бүхий л үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг дагаж мөрдөх, хүний эрхийг дээдлэхийн зэрэгцээ ёс зүйн хамгийн өндөр хэм хэмжээг сахин ажиллах суурь юм.

Монголын МСС-ийн нийт ажилтан, төлөөлөгчид энэхүү Ёс зүйн дүрэмтэй танилцаж, бүрэн ойлгосон, улмаар ажил хэргээ уг дүрэмтэй нийцүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд түүнийг зөрчсөн аливаа үйлдэл гаргаагүй болох тухай мэдэгдлээ Монголын МСС-ийн Хүний нөөцийн албанд жил бүр харгалзах маягтын дагуу, бичгээр гаргаж өгнө. Монголын МСС нь Ёс зүйн дүрмийг зөрчсөн аливаа үйлдлийг үл хүлцэх бөгөөд хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах хүртэл сахилгын арга хэмжээг тухай бүр авах болно.

Дүрмийг хэрэгжилтийг хангуулах үүргийг Монголын МСС-ийн Хуулийн ерөнхий зөвлөх хүлээх ба энэ хүрээнд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Дүрмийг зохих ёсоор хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах,
- Дүрмийг зөрчсөн байж болзошгүй аливаа тохиолдлын талаар мэдэгдэл, санал гомдол хүлээн авах,
- Дүрмийн тайлбар, үйлчлэл, хэрэгжилттэй холбогдуулан Монголын МСС-ийн ажилтнууд, төлөөлөгчдөөс ирүүлсэн асуулт, хүргүүлсэн хариултад хяналт тавих.

Энэхүү Дүрэм нь Монголын МСС-ийн Удирдах зөвлөл болон Монголын МСС-ийн дэргэд байгуулагдсан аливаа хорооны гишүүд, Монголын МСС-ийн Удирдлагын багийн гишүүд, нийт ажилтнууд, хэрэгжүүлэгч байгууллагууд болон хамтран ажиллагч бусад талуудад (нийтэд нь “Монголын МСС-ийн төлөөлөгчид” гэх) хамаарна. Монголын МСС нь Дүрмийг өөрийн цахим хуудаст байрлуулах бөгөөд харилцаж, хамтран ажиллаж буй аливаа хувь хүн, байгууллагад уг Дүрмийн талаар мэдээлэх, тэдгээр талууд нь Дүрмийг зөрчихгүй байхад чиглэсэн хүчин чармайлт гарган ажиллана.

Гарын үсэг:

Ёс зүйн хэм хэмжээ

Зохист зан байдал

Монголын МСС-ийг төлөөлж буй хэн боловч байгууллагын дотоод болон гадаадад чиг үүргээ гүйцэтгэх, ажил хэрэг явуулахдаа Дүрмийг чандлан сахиж, Монголын МСС-ийн бодлого, дүрэм журамтай, нэн ялангуяа энэхүү Дүрэмтэй зөрчилдөх аливаа нөхцөл байдалд орох, зүй бус үйлдэл гаргахаас зайлсхийж, Хөдөлмөрийн гэрээнд заасан аливаа шаардлагаас гадна ёс зүйт, чигч шударга байдал, ажлын үр дүн, ур чадварын хамгийн өндөр хэм хэмжээг тогтмол баримтлахыг эрмэлзэнэ. Монголын МСС-ийн аливаа төлөөлөгч ажил үүргээ гүйцэтгэх үедээ зүй бус үйлдэл гаргаж буй гэх ойлголт ч төрүүлэхээс зайлсхийх нь зүйтэй.

Албан хувцаслалт

Нийт ажилтнууд өөрсдийн гүйцэтгэж буй ажил үүрэгтээ нийцсэн, албан ёсны байдлаар хувцаслах ба албан хувцас нь цэвэр цэмцгэр, энгийн, биед эвтэй байвал зохино. Хувцаслалтад дараах ерөнхий шаардлага тавигдана:

- Хувцасны их биеийн материал нэвт гэрэлтдэггүй байх,
- Зохисгүй зураг, шошго, тэмдэглэл, үсэг, чимэглэл сэлтийг агуулаагүй байх,
- Дотуур хувцас ил гараагүй байх,
- Нуруу, цээж, бэлхүүс, мөр далд байх,
- Шорт, юбка, даашинзны урт өвдөгнөөс дээш гуравны хоёроос багагүй байх.

Монголын МСС-г төлөөлөн албан ёсны, эсхүл хэвлэл мэдээллийн арга хэмжээнд оролцох тохиолдолд байгууллагын таних тэмдгийг харуулсан хувцас өмсөж болно.

Авлига, санхүүгийн луйвраас ангид байх нь

Мянганы сорилтын корпорацын авлига, санхүүгийн луйврын эсрэг бодлого нь Монголын МСС-ийн нийт төлөөлөгчид болон Монголын МСС-ийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй хувь хүмүүс, байгууллагуудад нэгэн ижил хамаарна. Уг бодлогын дагуу Монголын МСС-ийн ажилтнууд болон Монголын МСС-ийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй хэн боловч авлига, хээл хахууль авах, өгөх, авах болон өгөхийг санал болгох, эсхүл ийнхүү завдахыг хориглох ба авлига, хээл хахууль, луйврын шинжтэй аливаа бусад үйл ажиллагаанд оролцохыг хатуу хориглоно. Монголын МСС-ийн төлөөлөгчид болон хэрэгжүүлэгч байгууллагууд нь авлигын эсрэг Монгол Улсын холбогдох бүх хууль тогтоомж, тухайлбал, төрийн албан хаагч, эсхүл гэрээт этгээдийн албан ёсны шийдвэр, үйлдэлд нөлөөлөх зорилгоор мөнгөн болон бусад үнэ бүхий зүйлийг (шууд болон шууд бусаар) шан харамж болгон өгөх, амлах, санал болгохыг хориглосон аливаа хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой.

Авлига, хээл хахууль, хууль бус, ёс зүйгүй байдлыг үл хүлцэх нь

Монголын МСС нь Монголын МСС-ийн аливаа төлөөлөгч, гэрээт байгууллагуудтай холбоотой авлига, хээл хахуулийн болон хууль бус, ёс зүйгүй аливаа бусад үйлдлийг үл хүлцэх бодлогыг баримтална. Монголын МСС нь тухайн улсад нийтлэг тогтсон жишигт нийцэх эсэхээс үл хамааран өөрийн бодлого, дүрэм журмаас гадна дотоодын холбогдох бүх хууль тогтоомжийг чандлан сахих шаардлагыг тавьдаг бөгөөд Монголын МСС-ийн аливаа төлөөлөгч энэхүү Дүрмийг зөрчсөн нь тогтоогдвол хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах хүртэлх сахилгын арга хэмжээг тухай бүр авах болно.

Гарын үсэг:

Мэдээлэх үүрэг

Мянганы сорилтын корпорацын авлига, санхүүгийн луйврын эсрэг бодлогын дагуу Монголын МСС-ийн аливаа төлөөлөгч авлига, хээл хаууль, луйврын шинжтэй байж болзошгүй аливаа тохиолдлын талаар дараах хаягийн аль нэгэнд шуурхай мэдээлэх үүрэгтэй. Үүнд:

- МСК-ын Авлига, санхүүгийн луйврын эсрэг багт (Hotline@mcc.gov) хаягаар хандах ба уг баг нь Ерөнхий хянан шалгагчийн газартай хамтран уг мэдээллийг хянаж үзсэний дараа уг хэргийн талаар МСК, Монголын МСС эсхүл тухайн орны эрх бүхий байгууллагад хандах эсэхийг шийдвэрлэнэ.
- Ерөнхий хянан шалгагчийн газарт (<https://oig.usaid.gov/content/mcc-hotline-report-fraud-or-corruption>) хаягаар шууд хандах.

Монголын МСС болон Монголын МСС-ийн ажилтан, төлөөлөгчид нь хууль бус, ёс зүйгүй үйлдэл, энэхүү дүрмийг зөрчсөн талаар Монголын МСС-ийн Хүний нөөцийн алба, Хуулийн ерөнхий зөвлөх, Гүйцэтгэх захирал, эсхүл МСК болон Ерөнхий хянан шалгагчийн газарт мэдээлсэн аливаа ажилтан, төлөөлөгчийн эсрэг хариу арга хэмжээ авахыг хатуу хориглоно.

Төрийн албан хаагчдад бэлэг, шан харамж өгөх, үзвэр үйлчилгээгээр хангахыг хориглох нь

Монголын МСС-ийн төлөөлөгчид нь дараах этгээдэд мөнгө, бэлэг, шан харамж, хөнгөлөлт, тэтгэмж (шууд болон шууд бусаар) өгөх, үзвэр, үйлчилгээгээр хангах, эсхүл ийнхүү санал болгохыг хориглоно. Үүнд:

- Монголын МСС-тай хамтран ажилладаг, хамтран ажиллаж байсан, эсхүл хамтран ажиллахаар төлөвлөж буй засгийн газрын болон засгийн газар хоорондын аливаа (төв болон орон нутгийн захиргааны байгууллага, АНУ-ын Засгийн газрын байгууллага, хоёр талт, олон талт хамтын ажиллагааны болон олон улсын байгууллага г.м) байгууллагад одоо болон өмнө нь ажиллаж байсан ажилтан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд, хамаарал бүхий этгээдэд,
- Бизнесийн давуу тал олж авах зорилгоор төрийн аливаа албан тушаалтан, Засгийн газрын аливаа (төв болон орон нутгийн захиргааны байгууллага, АНУ-ын Засгийн газрын байгууллага, хоёр талт, олон талт хамтын ажиллагааны болон олон улсын байгууллага г.м) байгууллагын ажилтан, төрийн албан тушаалд нэр дэвшигч, улс төрийн нам, улс төрийн намын албан тушаалтанд.

Бэлэг, шан харамж өгөх, үзвэр үйлчилгээгээр хангах санал хүлээх авах

Монголын МСС-ийн ажилтан нь гэрээт болон гэрээ байгуулах магадлалтай аливаа байгууллага, ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч, зөвлөх байгууллага болон өмнө нь, эсхүл одоо хамтран ажиллаж буй аливаа этгээд, хувь хүнээс нэг удаад 25 ам.доллар, дараалсан 12 сарын хугацаанд нийт 50 ам.доллар буюу түүнээс өндөр дүн бүхий мөнгө, бэлэг дурсгалын зүйл, бараа бүтээгдэхүүн, үзвэр, үйлчилгээ зэргийг хүлээн авахыг хориглоно. Ирүүлсэн бэлгийг хүлээн авахын өмнө Монголын МСС-ийн Хуулийн ерөнхий зөвлөхөд заавал мэдэгдэх ба энэхүү дүрэмд заасны дагуу хүлээн авах боломжгүй бэлгийг буцааж хүргүүлнэ.

Гарын үсэг:

Монголын МСС-ийн Хүний нөөцийн гарын авлага – Хөдөлмөрийн дотоод журмын Нэгдүгээр хавсралт

Өмнө дурдсанчлан Монголын МСС-ийн аливаа төлөөлөгч ёс зүйт, чигч шударга байдал, ажлын үр дүн, ур чадварын хамгийн өндөр хэм хэмжээг тогтмол баримтлан ажиллах бөгөөд хийж, хэрэгжүүлж буй аливаа үйлдэл, үйл ажиллагаа нь тэрхүү хариуцлагыг ухамсарлан биелүүлж буй гэсэн олон нийтийн итгэл үнэмшлийг бататгаж байх ёстой. Ийм ч учир хэрэв холбогдох мэдлэг, мэдээлэл бүхий аливаа хүн хөндлөнгөөс дүгнээд тухайн ажилтны ёс зүй, хараат бус, шударга байдалд эргэлзэхэд хүрч болзошгүй бол уг бэлгийг ажилтан хэдий хүлээн авахыг хориглоогүй байсан ч татгалзах нь зүйтэй юм.

Хувь авах, хөнгөлөлт эдлэх зэргийг хориглох нь

Монголын МСС-ийн төлөөлөгчид шууд болон шууд бус байдлаар хувьдаа хөнгөлөлт, хувь хүртэх, шан харамж авах, авахыг завдах, авахаар шаардахыг хориглоно. Үүнд зөвхөн бэлэн мөнгө бус, бусад үзвэр, үйлчилгээ зэрэг үнэ бүхий бусад эд зүйл, үйлчилгээ орно.

Байгууллагын тайлан, бүртгэл

Монголын МСС-ийн аливаа тайлан, бүртгэлд ямар ч үндэслэлээр хуурамч болон төөрөгдүүлсэн мэдээлэл оруулахыг хориглох бөгөөд дагалдах бүртгэл, мэдээлэлгүй аливаа хөрөнгө, санхүүжилт байршуулахыг хориглоно. Бүх гүйлгээний бүртгэлийг Монголын МСС болон холбогдох байгууллагуудын тайлан тооцоонд зохих ёсоор тусган хадгална. Төлбөрийг тайлан бүртгэлд зааснаас өөр зориулалтаар хийхгүй.

Монголын МСС-аас гадуурх үйл ажиллагаа

Хувь хүний биеэ авч явах байдал

Монголын МСС-ийн төлөөлөгчид ажлын болон ажлын бус цагийн аль алинд өөрийн ажил үүргийн гүйцэтгэл болон Монголын МСС-ийн нэр хүнд, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байдлаар биеэ авч явна.

Ажил олгогч, ажилтан хоорондын итгэлцэл ба давхар ажил эрхлэлт

Компакт хэрэгжих хугацаанд Монголын МСС-ийн ажилтнууд гэрээнд заагдсан ажил үүргээс гадуур давхар ажил эрхлэх хүсэлтэй бол энэ тухайгаа урьдчилан албан ёсоор мэдэгдэх үүрэг хүлээнэ. Гадуур ажил эрхэлсэн тохиолдолд энэхүү гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын цалин хөлсийг МСК-ын санхүүжилтээс олгохгүй байж болно. Мөн түүнчлэн, ажилтнууд Монголын МСС-д ажиллах хугацаандаа Монголын МСС-тай ижил төстэй үйл ажиллагаа эрхэлж буй аливаа этгээдэд ажилд орохоор хэлэлцээ хийх, эсхүл Монголын МСС-тай хамтран ажиллаж, ажил хэрэг явуулж буй болон хамтран ажиллахыг зорьж буй аж ахуйн нэгж, байгууллагад ажилд орох, ажилд орохоор хүсэлт гаргахыг хориглоно.

Гишүүнчлэл

Монголын МСС нь нийгмийн хариуцлагатай гишүүн байхыг хэзээд эрмэлзэх бөгөөд ажилтнуудаа олон нийтийн болон мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд оролцохыг дэмжинэ. Эдгээр үйл ажиллагаанд хариуцлагатай оролцсоноор Монголын МСС, Монголын МСС-ийн ажилтнууд болон олон нийтэд өргөн утгаараа ашиг тустай байх боломжтой. Нөгөө талаас ажилтан нь Монголын МСС-ийн Ашиг сонирхлын зөрчлийн тухай бодлогыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд аливаа үйл ажиллагаанд оролцохын өмнө тэдгээрт оролцсоноор ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх, эсхүл тийм зөрчил үүсч байгаа мэт

Гарын үсэг:

Монголын МСС-ийн Хүний нөөцийн гарын авлага – Хөдөлмөрийн дотоод журмын
Нэгдүгээр хавсралт

харагдах эсэхийг харгалзан үзэж, эрсдэлтэй гэж дүгнэсэн тохиолдолд уг үйл ажиллагаанд оролцохгүй байх талаар Хуулийн ерөнхий зөвлөхтэй зөвлөх нь зүйтэй.

Улс төрийн хувь нэмэр ба үйл ажиллагаа

Ажилтан нь Монголын МСС-д ажиллах хугацаандаа улс төрийн нам, улс төрийн албан тушаалд нэр дэвшигч, улс төрийн аливаа бүлэглэлээс хандив болон аливаа бусад хувь нэмэр шаардах, хүлээн авахыг хориглоно. Ажилтан нь ажлын цагаар, эсхүл Монголын МСС-ийн албан байранд, эсхүл Монголын МСС-ийн албан байрны ойролцоо ажлын болон ажлын бус цагаар, эсхүл Монголын МСС-ийн өмчийн болон түрээсийн тээврийн аливаа хэрэгсэл, цахилгаан хэрэгсэл (утас, компьютер, ижил төстэй бусад эд зүйлс)-ийг ашиглан улс төрийн нам, улс төрийн албан тушаалд нэр дэвшигч, улс төрийн намын амжилт, эсхүл амжилтгүй байдалд чиглэсэн улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

Тодруулбал, Ажилтан нь ажлын болон ажлын бус цагаар, Монголын МСС-ийн албан байранд, эсхүл түүний ойролцоо сонгуулийн аливаа материал, эд зүйлийг тараах, цахим шуудан илгээх, нийгмийн сүлжээнд нийтлэх, улс төрийн аливаа уулзалт, цуглаан зохион байгуулах, улс төрийн аливаа бэлэг тэмдэг бүхий хувцас, хэрэглэл хэрэглэх, бичмэл материал дэлгэн харуулахыг хориглох ба бусад ажилтнуудыг улс төрийн аливаа үйл ажиллагаанд уруу татахыг хориглоно. Монголын МСС-ийн төлөөлөгчид улс төрийн үйл ажиллагаанд оролцох, хандив, хувь нэмэр оруулах замаар Засгийн газрын худалдан авах ажиллагааны шийдвэрт (шууд болон шууд бус байдлаар) нөлөөлөх, аливаа бусад байдлаар хувийн ашиг хонжоо хайхыг хориглоно.

Ашиг сонирхлын зөрчил

Монголын МСС-ийн нийт ажилтан, төлөөлөгчид Монголын МСС-ийн Ашиг сонирхлын зөрчлийн тухай бодлогыг мөрдөж ажиллана.

Зүй бус үйлдэл

Монголын МСС-ийн төлөөлөгч хэн боловч Монголын МСС-ийн бодлого, дүрэм журам, түүний дотор энэхүү Дүрэмд харшлах аливаа үйлдэл гаргах нь хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах хүртэлх сахилгын арга хэмжээ авах үндэслэл болно. Хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах үндэслэлээр дараах болон ижил төстэй бусад зөрчлийг тооцно. Үүнд:

- Хулгайлах, шамшигдуулах, бусдад шан харамж өгөх, хүлээн авах, тэдгээрийг шаардах, амлах, зуучлах, санал болгох, хуурамч баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, бүрдүүлэх болон гэмт хэргийн шинж чанартай, ёс зүйгүй, эсхүл шударга бус аливаа бусад үйлдэлд холбогдох,
- Бусдад тулган шаардалт, дарамт үзүүлэх, үгсэн хуйвалдах, залилах, авлига, хээл хахууль, луйвар зэрэг Монголын МСС болон МСК-ын бодлого, дүрэм, журмаар хориглосон аливаа үйлдэлд холбогдох,
- Ажлын байрны дарамт, бэлгийн дарамт үзүүлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, айлган сүрдүүлэх,
- Архи согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ ажилдаа ирэх; бусдын эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэлийг бий болгосон нь тогтоогдон хэвийн ажиллах үүргээ хангалтгүй гүйцэтгэж, Монголын МСС-г төлөөлж хуралд оролцох чадваргүй болох нь тогтоогдсон;

Гарын үсэг:

Монголын МСС-ийн Хүний нөөцийн гарын авлага – Хөдөлмөрийн дотоод журмын
Нэгдүгээр хавсралт

- Ажил үүргээ гүйцэтгэх үедээ, эсхүл Монголын МСС-ийн албан байр, тээврийн хэрэгсэл дотор согтууруулах ундаа, мансууруулах бодисын нөлөөнд орсон байх, улмаар бусдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрсдэлд оруулах, Монголын МСС-г төлөөлөн ажил үүргээ хэвийн гүйцэтгэх, хурал, арга хэмжээнд орох чадамжгүй байх,
- Албан үүргийнхээ дагуу танилцсан, олж мэдсэн нууц мэдээллийг бусдад дур мэдэн задруулах,
- Удирдлагаас өгсөн аливаа чиглэл, удирдамж, шийдвэрийг үл тоомсорлох, хэрэгжүүлэхээс татгалзах,
- Монголын МСС-ийн сонгон шалгаруулалтын үеэр болон ажиллах хугацаандаа санаатайгаар худал мэдээлэл, хуурамч бичиг баримт өгөх (үүнд ажлын байрны сонгон шалгаруулалтын үеэр хуурамч баримт бичиг, мэдээлэл өгөх мөн багтана),
- Энэхүү Дүрэм, хөдөлмөрийн гэрээ, Хүний нөөцийн гарын авлагаар хориглосон улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцох;
- МСК болон Монголын МСС-ийн хооронд, эсхүл тэдгээрийн ажилтнуудын хооронд солилцсон аливаа мэдээлэл, баримт бичигт санаатай болон санамсаргүйгээр худал, хууран төөрөгдүүлсэн, эсхүл алдаа мадагтай мэдээлэл оруулах, дамжуулах,
- Ажлын болон ажлын бус цагаар Монголын МСС-ийн үйл ажиллагаа, нэр хүндэд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болохуйц үйлдэл гаргах, үйл ажиллагаанд оролцох;
- Энэхүү Дүрмийг ноцтойгоор зөрчих, эсхүл давтан зөрчих.

Монголын МСС-ийн зарим бодлого, дүрэм, журмын хэрэгжилт чанд, заавал дагаж мөрдөх шаардлагатай байдаг бол зарим тодорхой дүрэм, журмын үйлчлэл тухайн нөхцөл байдлаас хамааран харьцангуй уян хатан байж болно. Жишээлбэл, ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөлийг ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдүүлгийг холбогдох талуудад гарган өгснөөр хялбар шийдвэрлэх боломжтой. Мөн түүнчлэн Монголын МСС-ийн аливаа бодлого, дүрэм, журмыг хэт үгчлэн дагаснаар хууль ёсны, зөвшөөрөгдөхүйц ажил хэргийн чухал боломжийг алдах эрсдэлтэй хэмээн холбогдох газар, нэгжээс дүгнэх тохиолдол байж болно.

Аливаа бодлого, дүрэм журмын үйлчлэлтэй холбоотой энэ мэт асуудлаар ажилтан Монголын МСС-ийн Хуулийн ерөнхий зөвлөхөд бичгээр хандан, хүсэлт гаргана. Хуулийн ерөнхий зөвлөх уг асуудлыг хянан үзсэний үндсэн дээр уг хүсэлтийг зөвшөөрөх үндэслэлтэй хэмээн дүгнэвэл Гүйцэтгэх захиралд мэдэгдэх ба Гүйцэтгэх захирал уг хүсэлтийг зөвшөөрсөн эсэх шийдвэрийг бичгээр албажуулан гаргана. Тухайн асуудлын ач холбогдол, мөн чанараас хамааран уг хүсэлтийг МСК руу явуулж, зөвшөөрөл авах шаардлагатай байж болно.

Дүрэмтэй танилцаж, хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл

Монголын МСС-ийн аливаа төлөөлөгч энэхүү Ёс зүйн дүрэмтэй танилцаж, ойлгон, хүлээн зөвшөөрсөн тухай дараах мэдэгдэлд гарын үсэг зуран баталгаажуулж, Хүний нөөцийн албанд жил бүр хүргүүлэх үүрэгтэй.

ДҮРЭМТЭЙ ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

..... [овог, нэр] миний бие Монголын МСС-ийн Ёс зүйн дүрмийн хувийг хүлээн авч, танилцсан бөгөөд уг Дүрмийн агуулга, тавьсан шаардлагыг ойлгон, хүлээн зөвшөөрч, баримталж ажиллахаа үүгээр мэдэгдэв.

Гарын үсэг:

Монголын МСС-ийн Хүний нөөцийн гарын авлага – Хөдөлмөрийн дотоод журмын
Нэгдүгээр хавсралт

Гарын үсэг:

Огноо:

Гарын үсэг: